

Хатагтай, ноёд оо,

Хүндэт зочид оо,

“Оюу толгой”-н Ханган нийлүүлэлтийн форумар та бүхэнтэй уулзаж буйдаа таатай байна.

Өнөөдөр, энэхүү танхимд 600 гаруй компанийн төлөөлөл хүрэлцэн ирсэн байгаа нь манай компани Монголын ханган нийлүүлэгчидтэй нягт хамтын ажиллагаа хөгжүүлж буйн тод илрэл юм.

“Оюу толгой”-н хамт олон өнгөрсөн жилүүдийг ололт амжилтаар дүүрэн үдлээ.

- “Оюу толгой” нь аюулгүй ажиллагаа, өрсөлдөх чадвараар дэлхийд тэргүүлэх, асар ирээдүйтэй зэсийн уурхайн нэг боллоо
2010 оноос хойш “Оюу толгой” компани 6 тэрбум гаруй ам.долларыг Монгол Улсад оруулж ирж, ханган нийлүүлэгчдэд төлсөн төлбөр, татвар, рояалти төлбөр, цалин зэрэгт зарцуулсан.
- Зөвхөн 2016 онд гэхэд 279 сая ам.долларыг дотоодын ханган нийлүүлэгчдэд зарцуулж, 210.6 сая ам.долларыг Монгол Улсын Засгийн газарт татвар, хураамж бусад төлбөрт төллөө.

Эдгээр амжилт нь Монгол Улсад ханган нийлүүлэлтийн тогтвортой сүлжээ бий болгох чиглэлээр тусгайлсан, урт хугацааны стратеги баримталж ажилласны үр дүн гэж дүгнэж болно.

Бид бүхэнтэй хамтран ажилладаг Монгол компаниудын тоо жил ирэх бүр нэмэгдэж, аюулгүй ажиллагаа, чанар, үнэ цэнийг хүргэхийн төлөө хамтдаа хичээнгүйлэн ажиллаж байна.

Ингэснээр бидний зарцуулж буй 10 төгрөг тутмын 8 төгрөг нь дотоодод зарцуулагдаж, 2 төгрөгийн худалдан авалт тутмын 1 төгрөг нь үндэсний компаниудад ноогдож байна.

Үүний цаана:

- “Оюу толгой” олон зуун компанитай хамтран ажиллаж байна.
- Эдгээр компани нь шууд болон шууд бус байдлаар мянга мянган ажлын байрыг Монгол Улсад тэр дундаа Өмнөговьд бий болголоо.
- Бид хамтдаа Монгол Улсад шинэ ур чадвар, технологи, чадавхи нэвтрүүлж, бий болгож байна.
- Бизнесийн ёс зүй, ажил хэргийн хамгийн өндөр стандартыг тогтоон, хамтдаа хэрэгжүүлж байна.
- Хамгийн чухал нь аюулгүй ажиллагааг дээдлэн, үйл ажиллагаандаа өөрчлөлт хийн, хүн нэг бүр ажлаа тараад эрүүл, саруул гэртээ харих нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Энэ үзүүлэлтийн цаана сорилт бэрхшээл биш, нөөц бололцоо оршиж байгаа бөгөөд, “Оюу толгой” компанийн анхаарах гол чиглэл байх болно.

Хэдэн хормын өмнө, шинэ технологи, үр чадвар нутагшуулж буй амжилтын эздийн нэгтэй та бүхэн танилцсан.

Өнөөдрийн арга хэмжээ өндөрлөхөд, дараа дараагийн амжилтыг бүтээх компаниуд энэ танхимаас төрөн гарна гэдэгт эргэлзэхгүй байна.

Та бүхэн, манай Худалдан авалтын газрын мэргэжилтнүүдээс мэдээлэл авч, уулзаж ярилцахаар ирсэн. Үйл ажиллагааны худалдан авалтын газрын дарга Эван Хилл, Гүний уурхайн худалдан авалтын газрын менежер Сара Холлин нар, өөрийн багийн хамт хүрэлцэн ирснийг танилцуулъя.

Хатагтай, ноёд оо,

Та бүхний анхаарлыг хоёр зүйлд онцлон хандуулаад үгээ өндөрлөө.

- Нэгдүгээрт, “Оюу толгой” нь дэлхий дээрх зэсийн хамгийн сайн ордын нэг төдийгүй хамгийн өрсөлдөх чадвар бүхий уурхайн нэг байх болно. Бидний эрхэм зорилго бол: Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, дэлхийд өрсөлдөхүйц зэсийн үйлдвэрлэлийг цогцлоож, Монгол улсын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах юм.
- Хоёрдугаарт, “Оюу толгой” бол үе дамжих уурхай юм. Та бид хамтдаа Монгол Улсыг олон улсын тавцанд таниулах үүргээ биелүүлэхэд бид таны итгэлт түнш байх болно.

“Оюу толгой”-н хамт олон, гэр бүлийн нэрийн өмнөөс, бидэнтэй хамт урт холын аянд зорин гарсан та бүхэндээ гүн талархал илэрхийлье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.